

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## АГУУЛГА

---

1. Аудитын гэрчилгээ .....	0
2. Аудитын тайлан .....	1
2.1. Оршил .....	1
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	1
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	2
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	3
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	3
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	4
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	4
2.9. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	5
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
Улсын драмын эрдмийн театрын дараагийн аудитаар уран бүтээлийн зардал, тогтмол зардал, цалингийн зардлын талаар авч үзнэ.....	5
2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	5
2.12 Шилэн дансны мэдээлэл.....	6
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	6
2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал .....	8
Балансын данстай холбоотой асуудал .....	8
Балансын данстай холбоотой асуудал .....	9
Балансын данстай холбоотой асуудал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	10
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/254  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын драмын эрдмийн театрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын драмын эрдмийн театрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын драмын эрдмийн театрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Улсын драмын эрдмийн театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Улсын драмын эрдмийн театрын захирал Д.Цэрэнсамбуу танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын драмын эрдмийн театрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын драмын эрдмийн театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 3-наас 2019 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Баян ташаагийн эх Аудит” ХХК-ийн аудитор Т.Хоролсүрэн, Д.Түмэндэмбэрэл, чанарын хяналтын менежер Ч.Чимгээ, аудиторын туслах Д.Балжирдорж, Г.Хишигдулам нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын драмын эрдмийн театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Баян ташаагийн эх Аудит” ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 41 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Улсын драмын эрдмийн театрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Улсын драмын эрдмийн театр нь “Мэргэжлийн өндөр түвшинд уран бүтээл туурвиж ард түмнийг соён гэгээрүүлж оюуны хөтөч нь байх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны тодорхойлсноор Улсын драмын эрдмийн театрын үйл ажиллагааны чиглэл нь уран бүлээл туурвиж ард түмнийг соён гэгээрүүлэх юм.

Улсын драмын эрдмийн театрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Улсын драмын эрдмийн театрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Соёлын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны хувьд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

#### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Улсын драмын эрдмийн театрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улсын драмын эрдмийн театр санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програм хангамж ашигладаг байна.

Улсын драмын эрдмийн театрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Улсын драмын эрдмийн театрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсөвт байгууллага нь үйл ажиллагааны нийт зардлаа төсөвлөж, үүний дагуу өөрийн үйл ажиллагаанаас болон төсвөөс орлого төвлөрүүлэн зардлаа санхүүжүүлдэг. Ашгийн бус зардалд суурилан санхүүгийн үр дүнг төсөвлөдөг байгууллагын хувьд нийт зардлыг суурь болгон авч үзэх нь тохиромжтой юм.

Улсын драмын эрдмийн театрын материаллаг байдлын суурийг 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,573,571.9 мянган төгрөгийн түүний 1 хувь болох 15,735.7 мянган төгрөгөөр тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 16 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 11 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн бөгөөд аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөг/ Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	33,478.9	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	1,464.1	
<b>Дүн</b>		<b>5</b>	<b>34,943.0</b>	

## 2.9. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### 2.9.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Улсын драмын эрдмийн театр нь тайлант хугацаанд Говийн аймгуудад хийсэн аялан тоглолтын томилолтын зардалд 8076.0 мянган төгрөг зарцуулсаныг үндсэн баримттай тулган шалгахад томилолтын зардал 194.0 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 60.0 мянган төгрөгөөр нийт 254.0 мянган төгрөгийг илүү зарлагдсан.

Энэ нь “иж бүрэн байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

### 2.9.1.2 Зардлын данстай холбоотой асуудал

Байгууллагын удирдлагын гаргасан тушаал шийдвэрийг мөрдөж ажиллаагүйгээс 1,210.1 мянган төгрөгний цалин хөлс илүү олгосон.

Энэ нь “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 13 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

Дээрх актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 1-ны дотор ирүүлэх.

## 2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Улсын драмын эрдмийн театрын дараагийн аудитаар уран бүтээлийн зардал, тогтмол зардал, цалингийн зардлын талаар авч үзнэ. Анхаарал татахуйц бусад чухал асуудал үгүй байна.

### 2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Улсын драмын эрдмийн театрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,437,464.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,415,194.7 мянган төгрөг буюу 98.45 хувьтай байгаа нь цалин хөлсний зардал 8,338.5 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 4,292.9 мянган төгрөгөөр хэмнэсэн нь жирэмсний чөлөөтэй ажиллагсадтай холбоотой юм. Мөн байр ашиглалтын зардлыг 5,771.3 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардлыг 2,174.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 1,545.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой юм.

Улсын драмын эрдмийн театр нь 2018 онд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 282,000.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 8,000.0 мянган төгрөг, нийт 290,000.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллаж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 370,375.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 8,000.0 мянган төгрөг тус тус төвлөрүүлж 2018 оны 9 дүгээр сарын 3-ны Сангийн сайдын 224 тоот тушаалаар 85,754.3 мянган төгрөгийг нэмэлт дансаар дамжуулан захиран зарцуулсан. Орлогын төлөвлөгөө давж биелэхэд Э Оюуны "Би эндээс явахгүй" шинэ уран бүтээлийг төрийн соёрхолт Н.Наранбаатар найруулан тавьж үзэгч түмний хүртээл болгосон нь нөлөөлсөн.

## 2.12 Шилэн дансны мэдээлэл

Улсын драмын эрдмийн театр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## 2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улсын драмын эрдмийн театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улсын драмын эрдмийн театрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Улсын драмын эрдмийн театрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 17,484.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.

Энэ нь “толилуулга ба тодруулга” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ыг зөрчсөн байна.

##### **Эрсдэл:**

Бараа материалд бүртгэлээр тавих хяналт сул

##### **Өгсөн зөвлөмж:**

Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ыг мөрдөж ажиллах

##### **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

2000 оноос хойш бараа материалын дансанд бүртгэлтэй байсан үндсэн хөрөнгө байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч 2019 онд үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэнэ.

### Балансын данстай холбоотой асуудал

#### 3.2.1 Илрүүлэлт:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй 8,694.2 мянган төгрөгний үндсэн хөрөнгө худалдан авч бараа материалын дансанд бүртгэсэн.

Энэ нь “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолыг зөрчсөн байна.

#### Эрсдэл:

Холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллахгүй байх

#### Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах

#### Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2018 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн Сангийн сайдын 224 тоот тушаалаар давсан орлогыг байгууллага захиран зарцуулах эрхийн дагуу тоос сорогч 3ш авсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч 2019 онд үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэнэ.

### Балансын данстай холбоотой асуудал

#### 3.3.1 Илрүүлэлт:

Старикс суудлын автомашины моторыг 2,900.0 мянган төгрөгөөр сольсон, дулааны шугам сүлжээнд дулааны тоолуур угсралтын ажилд зарцуулсан 4,400.0 мянган төгрөг нийт 7,300.0 мянган төгрөгийг капиталжуулж бүртгэлгүй шууд зардалд бүртгэсэн

Энэ нь “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг зөрчсөн байна.

#### Эрсдэл:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт сул

#### Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрдөж ажиллах, үндсэн хөрөнгийг капиталжуулах

#### Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аялан тоглолтоор Баянхонгор аймагт явж байх хугацаанд Старикс автомашины мотор цохисон тул яаралтай машиныг хэвийн үйл ажиллагаанд оруулах болсон учир мотор сольж Улаанбаатар хотод ирсэн. 2018 оны 10-р сард дулааны шугам задарч гэнэтийн гэмтэл гарсан тул зайлшгүй ажлын шаардлагаар төхөөрөмж авч тавьсан 2019 онд капиталжуулан бүртгэнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 1-ны дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>422,697,839.52</u></b>	<b><u>519,812,314.82</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	-
<b>32</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	300,960.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	300,960.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	422,697,839.52	519,511,354.82
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	4,590,360.00	5,370,832.00
35110	Тусгай зориулалттай материал	4,590,360.00	5,370,832.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	38,833,927.20	38,833,927.20
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	379,273,552.32	475,306,595.62
35470	Бусад хангамжийн материал	379,273,552.32	475,306,595.62
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,207,746,711.24</u></b>	<b><u>7,806,334,168.04</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,207,746,711.24	7,806,334,168.04
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,207,746,711.24	7,368,060,168.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,979,032,323.00	7,277,351,660.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,931,988,013.96	40,971,100.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	132,086,865.00	132,086,865.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	103,771,142.37	111,910,281.89
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	840,099,095.46	845,477,175.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	773,586,314.05	787,461,623.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	225,948,023.70	225,948,023.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	171,293,922.44	183,604,147.87
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	11,143,597.00	11,143,597.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	52,455,080.00	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	52,378,880.10	-
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	438,274,000.00
39301	Програм хангамж	2,800,000.00	2,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	2,800,000.00	2,800,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	-	438,274,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,630,444,550.76</u></b>	<b><u>8,326,146,482.86</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>819,853.81</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	819,853.81
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	819,853.81
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	819,853.81
41361	Байгууллагад төлөх өглөг	-	819,853.81
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>421</b>	<b>Урт хугацаат үнэт цаас</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,630,444,550.76</u></b>	<b><u>8,325,326,629.05</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,630,444,550.76	8,325,326,629.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,150,922,963.73	3,589,196,963.73
51101	Өмч: - төрийн	3,150,922,963.73	3,589,196,963.73
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(1,520,478,412.97)	(1,502,833,124.44)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,520,478,412.97)	(1,520,478,412.97)
51220	Тайлант үеийн үр дүн	-	17,645,288.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	6,238,962,789.76
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,630,444,550.76</u></b>	<b><u>8,326,146,482.86</u></b>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,506,617,469.20</b>	<b>1,591,217,270.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>312,014,969.20</b>	<b>292,620,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	305,514,969.20	292,620,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	305,514,969.20	292,620,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	145,227,710.00	284,620,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,457,250.00	8,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	157,830,009.20	
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	6,500,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	6,500,000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,194,602,500.00</b>	<b>1,298,596,470.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,094,602,500.00	1,152,842,080.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,094,602,500.00	1,147,464,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	5,378,080.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	100,000,000.00	145,754,390.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00	60,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	85,754,390.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,441,840,985.62</b>	<b>1,573,571,981.47</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,441,840,985.62</b>	<b>1,573,571,981.47</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,365,205,542.09	1,548,168,520.01
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	873,467,747.16	929,287,456.96
210101	Үндсэн цалин	784,920,959.30	796,229,851.82
210102	Нэмэгдэл	-	21,216,418.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	88,546,787.86	70,830,335.27
210104	Урамшуулал	-	41,010,851.15
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	98,022,744.34	108,078,505.35
210201	Тэтгэврийн даатгал	61,142,742.31	75,276,085.05
210202	Тэтгэмжийн даатгал	6,987,741.96	7,218,948.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,734,677.48	9,023,685.63
210204	Ажилгүйдлийн даатгал	1,746,935.50	1,804,737.13
210205	Эрүүл мэндийн даатгал	19,410,647.09	14,755,049.03
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	77,185,629.84	92,157,642.30
210301	Гэрэл, цахилгаан	39,956,220.50	47,311,849.00
210302	Түлш, халаалт	26,765,922.00	31,908,478.00
210303	Цэвэр, бохир ус	10,463,487.34	12,937,315.30
210304	Байрны түрээс		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,522,925.13	11,517,999.61
210401	Бичиг хэрэг	364,360.00	225,400.00
210402	Тээвэр, шатахуун	935,000.00	1,047,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,860,565.13	5,980,003.54
210404	Ном, хэвлэл	-	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,363,000.00	1,257,700.00
210408	Бараа материал акталсны зардал	-	2,707,896.07
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	28,610,221.00

Улсын драмын эрдмийн театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	-	7,300,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	21,310,221.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,700,000.00</b>	<b>14,980,000.00</b>
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	3,700,000.00	14,980,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>180,349,014.00</b>	<b>269,634,281.83</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	177,758,997.00	264,558,681.83
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	1,300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	790,017.00	691,200.00
210807	Газрын төлбөр	800,000.00	1,084,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>125,957,481.62</b>	<b>93,902,412.96</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,875,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	125,957,481.62	84,027,412.96
210904	Найдваргүй авлагын алдагдал		
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>76,635,443.53</b>	<b>25,403,461.46</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>71,030,900.00</b>	<b>-</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,580,900.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,450,000.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,604,543.53</b>	<b>25,403,461.46</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,604,543.53	25,403,461.46
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>64,776,483.58</b>	<b>17,645,288.53</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>64,776,483.58</b>	<b>17,645,288.53</b>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,352,264,190.00</b>	<b>1,585,839,190.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>149,134,960.00</b>	<b>292,620,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	149,134,960.00	292,620,800.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	149,134,960.00	292,620,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	145,227,710.00	284,620,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,907,250.00	8,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,203,129,230.00</b>	<b>1,293,218,390.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,094,602,500.00	1,147,464,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,094,602,500.00	1,147,464,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	100,000,000.00	145,754,390.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00	60,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	85,754,390.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	8,526,730.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	8,526,730.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,352,264,349.50</b>	<b>1,585,839,190.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,352,264,349.50</b>	<b>1,585,839,190.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,275,628,905.97</b>	<b>1,560,435,728.54</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	881,994,477.16	928,768,563.15
210101	Үндсэн цалин	809,152,477.16	842,047,187.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,842,000.00	86,146,000.00
210104	Урамшуулал	-	575,376.15
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	98,022,744.34	108,078,505.35
210201	Тэтгэврийн даатгал	61,142,742.31	75,276,085.05
210202	Тэтгэмжийн даатгал	6,987,741.96	7,218,948.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,734,677.48	9,023,685.63
210204	Ажилгүйдлийн даатгал	1,746,935.50	1,804,737.13
210205	Эрүүл мэндийн даатгал	19,410,647.09	14,755,049.03
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	77,185,629.34	92,157,642.30
210301	Гэрэл, цахилгаан	39,956,220.00	47,311,849.00
210302	Түлш, халаалт	26,765,922.00	31,908,478.00
210303	Цэвэр, бохир ус	10,463,487.34	12,937,315.30
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,522,925.13	9,654,103.54
210401	Бичиг хэрэг	364,360.00	635,400.00
210402	Тээвэр, шатахуун	935,000.00	1,047,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,860,565.13	5,980,003.54
210404	Ном, хэвлэл	-	330,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,363,000.00	1,661,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,000,000.00	3,600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	3,600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	46,252,471.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	10,400,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	35,852,471.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,700,000.00	14,980,000.00
210702	Дотоод албан томилолт	3,700,000.00	14,980,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	203,753,130.00	347,069,443.20

Улсын драмын эрдмийн театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	201,163,113.00	341,993,843.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	1,300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	790,017.00	691,200.00
210807	Газрын төлбөр	800,000.00	1,084,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,450,000.00</b>	<b>9,875,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,450,000.00	9,875,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>76,635,443.53</b>	<b>25,403,461.46</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>71,030,900.00</b>	<b>-</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,580,900.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33,450,000.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,604,543.53</b>	<b>25,403,461.46</b>
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,604,543.53	25,403,461.46
213304	Хөрөнгийн		
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(159.50)</b>	<b>≡</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>≡</b>	<b>≡</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(159.50)</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>				-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,150,922,963.73</b>	-	<b>(1,520,478,412.97)</b>	1,630,444,550.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	438,274,000.00			438,274,000.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>		-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		6,238,962,789.76		6,238,962,789.76
Тайлант үеийн үр дүн			17,645,288.53	17,645,288.53
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,589,196,963.73</b>	<b>6,238,962,789.76</b>	<b>(1,502,833,124.44)</b>	<b>8,325,326,629.05</b>

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,437,464,000.00	1,415,194,738.54	22,269,261.46	98.45
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,437,464,000.00	1,415,194,738.54	22,269,261.46	98.45
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,437,464,000.00	1,415,194,738.54	22,269,261.46	98.45
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	910,707,100.00	902,368,563.15	8,338,536.85	99.08
210101	Үндсэн цалин	823,731,300.00	815,647,187.00	8,084,113.00	99.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,185,200.00	86,146,000.00	39,200.00	99.95
210104	Урамшуулал	790,600.00	575,376.15	215,223.85	72.78
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	109,284,800.00	104,991,905.35	4,292,894.65	96.07
210201	Тэтгэврийн даатгал	72,856,588.00	72,189,485.05	667,102.95	99.08
210202	Тэтгэмжийн даатгал	7,285,656.80	7,218,948.51	66,708.29	99.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,107,071.00	9,023,685.63	83,385.37	99.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,821,414.20	1,804,737.13	16,677.07	99.08
210205	Эрүүл мэндийн даатгал	18,214,070.00	14,755,049.03	3,459,020.97	81.01
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	97,929,000.00	92,157,642.30	5,771,357.70	94.11
210301	Гэрэл, цахилгаан	35,067,100.00	47,311,849.00	(12,244,749.00)	134.9
210302	Түлш, халаалт	43,673,900.00	31,908,478.00	11,765,422.00	73.06
210303	Цэвэр, бохир ус	19,188,000.00	12,937,315.30	6,250,684.70	67.42
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,828,200.00	9,654,103.54	2,174,096.46	81.62
210401	Бичиг хэрэг	641,400.00	635,400.00	6,000.00	99.06
210402	Тээвэр, шатахуун	1,065,500.00	1,047,000.00	18,500.00	98.26
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,083,600.00	5,980,003.54	2,103,596.46	73.98
210404	Ном, хэвлэл	376,000.00	330,000.00	46,000.00	87.77
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,661,700.00	1,661,700.00	-	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	3,600,000.00	3,600,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,600,000.00	3,600,000.00	-	100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,500,000.00	25,498,081.00	1,919.00	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,400,000.00	4,400,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	21,100,000.00	21,098,081.00	1,919.00	99.99
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	15,000,000.00	14,980,000.00	20,000.00	99.87
210702	Дотоод албан томилолт	15,000,000.00	14,980,000.00	20,000.00	99.87
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	253,614,900.00	252,069,443.20	1,545,456.80	99.39
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	247,000,000.00	246,993,843.20	6,156.80	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,300,000.00	1,300,000.00	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,413,800.00	691,200.00	722,600.00	48.89

Улсын драмын эрдмийн театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210807	Газрын төлбөр	1,901,100.00	1,084,400.00	816,700.00	57.04
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,000,000.00	9,875,000.00	125,000.00	98.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	9,875,000.00	125,000.00	98.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			-	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,437,464,000.00	1,414,681,338.54	22,782,661.46	98.42
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,147,464,000.00	1,122,060,538.54	25,403,461.46	97.79
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,147,464,000.00	1,122,060,538.54	25,403,461.46	97.79
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	290,000,000.00	292,620,800.00	(2,620,800.00)	100.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	282,000,000.00	284,620,800.00	(2,620,800.00)	100.93
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	8,000,000.00	-	100.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>				
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	-	-
610001	Төсвийн байгууллага				
610002	Төсвөөс гадуур байгууллага				
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	-	-	-	-
620001	Удирдах ажилтан				
620002	Гүйцэтгэх ажилтан				
620003	Үйлчлэх ажилтан				
620004	Гэрээт ажилтан				

Хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.25	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2019/16/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:	Улсын драмын эрдмийн театр	Мянган төгрөгөөр
------------------------------	----------------------------	------------------

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 17,484.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.	17,484.70	Зөвлөмж	Захирал	Д.Цэрэнсамбуу
Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй 8,694.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч бараа материалын дансанд бүртгэсэн.	8,694.20	Зөвлөмж		
Старикс суудлын автомашины моторыг 2,900.0 мянган төгрөгөөр сольсон, дулааны шугам сүлжээнд дулааны тоолуур угсралтын ажилд зарцуулсан 4,400.0 мянган төгрөг нийт 7,300.0 мянган төгрөгийг капиталжуулж бүртэлгүй шууд зардалд бүртгэсэн.	7,300.00	Зөвлөмж		
Улсын драмын эрдмийн театр нь тайлант хугацаанд Говийн аймгуудад хийсэн аялан тоглолтын томилолтын зардалд 8076.0 мянган төгрөг зарцуулсаныг үндсэн баримттай тулган шалгахад томилолтын зардал 194.0 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 60.0 мянган төгрөгөөр нийт 254.0 мянган төгрөгийг илүү зарлагдсан.	254.0	Төлбөрийн акт		
Байгууллагын удирдлагын гаргасан тушаал шийдвэрийг мөрдөж ажиллаагүйгээс 1,210.1 мянган төгрөгийн цалин хөлс илүү олгосон	1,210.1	Төлбөрийн акт		
<b>Дүн</b>	<b>34,943.0</b>			



